



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/122/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.dornogovi.audit.mn](http://www.dornogovi.audit.mn)

Сайншанд хот  
2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734 Цахим хаяг: [Dornogovi@audit.gov.mn](mailto:Dornogovi@audit.gov.mn)

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 70523020 Цахим хаяг: .....

Аудитор: О.Нарангарав

Утас: 70523020 Цахим хаяг: [Narangarav.o@audit.gov.mn](mailto:Narangarav.o@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудитын тайлан .....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	11
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.2 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	20



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

2020.02.12 № 1-6/35  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН  
ДАРГА А.ДАШНЯМ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Онцгой байдлын газар нь 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

010020022

### Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Онцгой байдлын газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг байгууллагын дарга А.Дашням танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 05-аас 2020 оны 02 дугаар сарын 06-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор О.Нарангарав хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 25/26 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Орон нутагт гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, гамшгийн эмзэг байдал, эрсдэлийг бууруулах"-д оршино.

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Удирдлага зохион байгуулалт, эрх зүйн баримт бичиг хэрэгжүүлэх
- Удирдлагын манлайлал, хүний нөөцийн хөгжлийг хангаж, чадавхыг бэхжүүлэх
- Гамшгаас урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, олон нийттэй харилцах
- Гамшгийн шуурхай удирдлага, зохицуулалтын чадавхыг дээшлүүлж, бэлэн байдлыг хангах
- Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлж, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулах
- Улсын нөөцийн удирдлага, зохицуулалтаар хангах, зохион байгуулах
- Төсөв, санхүү, хангалт, аж ахуйн бодлого зохицуулалт
- Дотоодын ажил үйлчилгээ зохион байгуулах, хэрэгжүүлэх

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Онцгой байдлын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 2 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,440,723.3 мянган төгрөгөөс тооцон 14,407.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 29,672.4 мянган төгрөгөөр тооцсон нь материаллаг байдлыг 2019 оны эхний хагас жилийн үзүүлэлтээр тооцсон, мөн гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг нарийвчлан авч үзэх шаардлагатай гэж үзэж хамгийн бага үзүүлэлт болох нийт зардлыг сонгон авч түүний 1 хувиар тооцсонтой холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 479,921.8 мянган төгрөгөөр буюу 10.93 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал 122,017.2 мянга, үндсэн хөрөнгө 358,104.9 мянга, өр төлбөр 4,179.3 мянга, цэвэр хөрөнгө өмчийн дүн 475,742.5 мянган төгрөгөөр тус тус өсөж, авлага 200.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Зөрүү	
				Дүн	Хувь
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>550,540.52</b>	<b>672,357.49</b>	<b>121,816.97</b>	<b>22.13</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-	-	#DIV/0!
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-	-	#DIV/0!
33	АВЛАГА	630.35	430.10	(200.24)	-31.77
34	УРЬДЧИЛГАА	-	-	-	#DIV/0!
35	БАРАА МАТЕРИАЛ	549,910.17	671,927.39	122,017.22	22.19
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-	-	#DIV/0!
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,840,961.66</b>	<b>4,199,066.53</b>	<b>358,104.87</b>	<b>9.32</b>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-	-	#DIV/0!
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,840,961.66	4,199,066.53	358,104.87	9.32
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>4,391,502.17</b>	<b>4,871,424.02</b>	<b>479,921.84</b>	<b>10.93</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>207.80</b>	<b>4,387.11</b>	<b>4,179.31</b>	<b>2011.22</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	207.80	4,387.11	4,179.31	2011.22
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-	-	#DIV/0!
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,391,294.37</b>	<b>4,867,036.91</b>	<b>475,742.53</b>	<b>10.83</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>4,391,502.17</b>	<b>4,871,424.02</b>	<b>479,921.84</b>	<b>10.93</b>

Авлага дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны авлага бүрэн барагдсан нь харин тайлант онд албан хаагчтай холбоотой 300.0 мянган төгрөгийн авлага, мөн нэмэлтийн дансанд гэрээтийн цалин 130.1 мянган төгрөг орж жилийн эцэст татагдаж, авлагаар бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 122,017.2 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 2,412.5 мянга, эм боох материал 661.1 мянга, бичиг хэрэг 595.1 мянга, аж ахуйн материал 14,447.5 мянга, хүнсний материал 22,021.1 мянга, бусад хангамжийн материал 81,624.9 мянга, мал амьтанд 850.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, түлш шатах тослох материал 127.9 мянга, сэлбэг хэрэгсэл, барилгын засварын материал 467.0 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Онцгой байдлын ерөнхий газраас 102,755.8 мянган төгрөгийн албаны дүрэмт хувцас олгож, Үндэсний аврах бригадаас 850.0 мянган төгрөгийн сургалтын 1 нохойг шилжүүлэн авсан, мөн ОБЕГ-ын 2019 оны А/251 тушаалаар ээлжийн алба хаагчийн хоолны зардал нэмэгдэж хоолны зардлыг нэмж ангийн харьяа 5 алба хэлтсийн хүнсний материалд 185 нэр төлийн 22,021.1 мянган төгрөгийн нөөцийг бүрдүүлж бэлтгэл бэлэн байдал хангах үүрэг гүйцэтгэсэн нь материал өсөхөд голлон нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь барилга байгууламж 23,900.0 мянга, авто тээврийн хэрэгсэл 566,600.0 мянга, машин тоног төхөөрөмж 15,365.7 мянга, тавилга эд хогшил 5,339.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Дорноговь аймагт 2019 онд “Говийн чоно” ОУ-ын дадлага, сургуулилт зохион байгуулагдсан холбоотой аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс 45,216.3 мянган төгрөгийн хөрөнгийн зардлыг олгож 16,700.0 мянган төгрөгөөр тээврийн хэрэгсэл, 20,286.3 мянган төгрөгөөр машин тоног төхөөрөмж, 8,230.0 мянган төгрөгөөр тавилга эд хогшил худалдан авсан байна. Мөн ОБЕГ-аас барилгын дээврийн засварын санхүүжилт 23,900.0 мянган төгрөгийг олгож засвар үйлчилгээг холбогдох журмын дагуу зохион байгуулж данс бүртгэлд тусгасан байна.

Тайлант онд хөрөнгө оруулалтаар нийт 552,799.0 мянган төгрөгийн хөрөнгө олгогдсон байна. Үүнд:

- Засгийн газрын хөрөнгө оруулалтаар 490,000.0 мянган төгрөгийн гал унтраах тусгай зориулалттай автомашин
- Онцгой байдлын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар холбоо зарлан мэдээллийн бэлтгэл бэлэн байдлыг хангах зориулалт бүхий 3 нэр төрлийн 2,899.0 мянган төгрөгийн холбооны хэрэгсэл
- Аймгийн хөрөнгө оруулалтаар гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, урьдчилан сэргийлэх гамшгийн голомтыг арилгах арга хэмжээг шуурхай зохион байгуулахад дэмжлэг үзүүлж 59,900 мянган төгрөгийн шуурхай албаны автомашиныг тус тус олгосон байна.

Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын газрын 2019 оны А-5/1323 албан тоотоор 1,281.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 6,832.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 2019 оны А/248 дугаар тогтоолоор 2,595.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг тус тус актлан данс бүртгэлээс хассан байна.

Биет бус хөрөнгөнд 55.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал нэмэгдэж үлдэгдэл 55.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд нийт 263,810.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал нэмэгдэж, актлагдсан хөрөнгийн 10,710.1 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг бүртгэлээс хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 4,179.3 мянган төгрөгөөр өссөн нь оны эхний 207.8 мянган төгрөгийн өр төлбөр бүрэн барагдаж, жилийн эцэст нэмэлт дансанд орсон гэрээт алба хаагчийн цалин татагдсаныг өглөгөөр бүртгэж, мөн 2019 онд гал түймэр унтраах зориулалттай болон шуурхай албаны 3 автомашин шинээр нэмэгдсэнтэй холбогдуулан өдөр тутмын бэлтгэл бэлэн байдал хангахад шаардагдах шатахууны зардал хүрэлцэхгүйн улмаас тээвэр шатахууны зардалд 4,257.0 мянган төгрөгийн өглөг үүссэн нь

шалтгаалжээ. Өглөгийг тооцоог харилцагч байгууллагуудтай нийлж баталгаажуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,867,036.9 мянган төгрөг болж 475,742.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь шалтгаалжээ. Энэ нь тайлант онд хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө, бараа материал нэмэгдсэнийг илэрхийлж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 913.5 мянган төгрөг нь үндсэн хөрөнгө акталж данснаас хассантай холбоотой дахин үнэлгээний данс буурсан байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Дансны код	Орлогын ангилал	Тайлант оны		Тайлант оны зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1310	Улсын төсвөөс санхүүжих	2,186,422.80	2,186,422.80	-	100.00
	<b>Нийт дүн</b>	<b>2,186,422.80</b>	<b>2,186,422.80</b>	<b>-</b>	<b>100.00</b>

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 2,186,422.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,186,422.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2,186,422.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Улсын төсвөөс 2,186,422.8 мянган төгрөгийн санхүүжилттэй ажилласан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,995,425.5 мянган төгрөг буюу 91.3 хувьтай байна. Үүний: Албан хаагчдын цалин, НДШ-ийн зардал 1,723,887.3 мянган төгрөг нь нийт зардлын 86.4 хувь, бараа ажил үйлчилгээний бусад зардал 263,206.2 мянган төгрөг нь нийт зардлын 13.2 хувь, урсгал шилжүүлгийн зардал 8,332.0 мянган төгрөг нь нийт зардлын 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Жилийн эцэст өмнөх оны авлагын барагдуулалтын орлого 300.0 мянга, урсгал зардлын хэмнэлт 190,997.3 мянган төгрөг нийт 191,297.3 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагаас сургалтын зардал 1,712.7 мянга төгрөг, "ГОВИЙН ЧОНО-2019" гамшгийн хор уршгийг арилгах Олон улсын сургалт дадлага сургуулийн бэлтгэл ажлыг хангах, арга хэмжээнд зориулан засаг даргын нөөц сангаас 216,089.3 мянган төгрөг, Дээд шатны төсвийн захирагчаас мал, амьтны гоц халдварт шүлхий, хонины цэцэг өвчний улмаас зориудаар устгасан малын нөхөн төлбөр, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдын томилолт, урамшууллын зардал болон дээврийн урсгал засварын зардалд нийт 352,689.0 мянган төгрөг, ОБЕГ-ын дарга болон УБТЗамын даргын байгуулсан гэрээний дагуу гал түймрийн

улсын хяналтын гэрээт байцаагчийн цалин 22,825.8 мянга төгрөг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас тендерийн материалын хураамжийн төлбөрт 49.5 мянган төгрөг нийт 593,366.3 мянган төгрөгийн санхүүжилтийг холбогдох дансанд бүртгэсэн байна.

Нийт санхүүжилтийг зарцуулалтаар авч үзвэл “ГОВИЙН ЧОНО-2019” гамшгийн хор уршгийг арилгах Олон улсын сургалт дадлага сургуулийн бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах арга хэмжээний зардалд 216,138.8 мянган төгрөг, “Монгол орны уур амьсгалын өөрчлөлт болон байгалийн гамшгаас үүдэлтэй шилжилт хөдөлгөөн” сургалтын зардалд 1,712.7 мянган төгрөг, мал амьтны гоц халдварт шүлхий, хонины цэцэг өвчний улмаас зориудаар устгасан малын нөхөн төлбөр, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчид, иргэдийн томилолт, урамшууллын зардалд 352,688.9 мянган төгрөг, гэрээт байцаагчийн цалинд 22,695.7 мянган төгрөг нийт 593,236.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 130.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 5 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 957.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 957.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

### **1. Зардлын данстай холбоотой асуудал**

Аймгийн Засаг даргын 2019 оны 1/1165 тоот албан бичгийг үндэслэн байгууллагын даргад нэг сарын үндсэн цалинтай тэнцэх урамшуулал тооцож олгосон байна.

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна МУ-ын Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 40 дүгээр зүйлийн 40.1, 40.4.2 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитаар албан шаардлага тогтоохоор шийдвэрлэв.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2007 оны 128 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Тусгай зориулалтын автомашин техник, зэвсэглэмжийн өдөр тутмын бэлтгэл бэлэн байдал хангах шатахуун, тосны зарцуулалтыг тооцох журам”-ын дагуу 6 тусгай автомашины бэлэн байдал хангахад зориулан 2019 онд нийт 22,807.7 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Онцгой байдлын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 149 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцроож байршуулсан мэдээлэл байхгүй байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 254.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосноос 254.4 мянган төгрөгийг барагдуулсан байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### **“Зөрчилгүй” дүгнэлт**

Дорноговь аймгийн Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

#### 4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөг/	
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>550,540,517.47</b>	<b>672,357,490.25</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	630,348.00	430,104.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	300,000.00	300,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	330,348.00	130,104.00
3351	Байгууллагаас авах авлага	330,348.00	130,104.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	549,910,169.47	671,927,386.25
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	436,909,798.33	439,983,372.11
35110	Тусгай зориулалттай материал	436,137,336.21	438,549,786.21
35130	Эм боох материал	772,462.12	1,433,585.90
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	113,000,371.14	231,094,014.14
35410	Бичиг хэргийн материал	5,192,825.00	5,787,975.00
35420	Аж ахуйн материал	18,133,107.79	32,580,566.79
35430	Сэлбэг хэрэгсэл	47,321,416.00	46,964,416.00
35440	Түлш, шатах тослох материал	11,540,250.00	11,412,294.00
35450	Барилгын засварын материал	110,000.00	-
35460	Хүнсний материал	82,650.00	22,103,798.00
35470	Бусад хангамжийн материал	30,620,122.35	112,244,964.35
35600	Мал амьтад	00.00	850,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,840,961,655.60</b>	<b>4,199,066,525.93</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,840,961,655.60	4,199,066,525.93
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,321,069,155.58	2,679,229,025.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,419,883,156.29	1,443,783,135.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	(36,703,226.89)	(118,548,360.61)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,900,631,187.15	2,467,231,187.15
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,427,641,823.00)	(1,502,183,022.98)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,738,816,775.92	1,754,182,504.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,295,414,318.68)	(1,391,302,771.59)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	67,303,227.56	72,642,750.83
39208	Хуримтлагдсан элэгдэл	(46,750,512.13)	(47,388,255.73)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,502,140.00	1,502,140.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(557,450.64)	(690,281.28)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1,519,892,500.02	1,519,837,500.06
39301	Програм хангамж	2,719,500.00	2,719,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,471,999.98)	(2,526,999.94)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,519,645,000.00	1,519,645,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,391,502,173.07</b>	<b>4,871,424,016.18</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>207,800.00</b>	<b>4,387,109.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	207,800.00	4,387,109.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	207,800.00	4,387,109.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	130,104.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	4,257,005.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	207,800.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	207,800.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,391,294,373.07</b>	<b>4,867,036,907.18</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,391,294,373.07	4,867,036,907.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,564,959,256.78	2,564,959,256.78
51101	Өмч: - төрийн	2,564,959,256.78	2,564,959,256.78
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,378,638,544.32	1,855,294,567.43
51210	Өмнөх үеийн үр дүн	1,378,638,544.32	1,379,552,033.32
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	475,742,534.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	447,696,571.97	446,783,082.97
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,391,502,173.07</b>	<b>4,871,424,016.18</b>

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,185,228,448.25</b>	<b>3,442,978,637.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>138,557,139.25</b>	<b>110,390,492.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	138,557,139.25	110,390,492.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	138,557,139.25	110,390,492.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	138,557,139.25	110,390,492.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,046,671,309.00</b>	<b>3,332,588,145.50</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,907,015,080.00	2,186,422,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,882,643,000.00	2,186,422,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	139,656,229.00	593,366,290.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	745,000.00	1,712,700.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,987,140.00	216,089,290.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	102,075,000.00	352,688,984.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,849,089.00	22,875,316.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	00.00	552,799,055.50
133003	Хөрөнгийн	00.00	552,799,055.50
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,659,280,417.88</b>	<b>2,967,236,103.39</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,659,280,417.88</b>	<b>2,967,236,103.39</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,512,460,969.21	2,767,606,797.39
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,498,092,092.00	1,697,503,026.00
210101	Үндсэн цалин	1,036,578,292.00	1,111,894,956.00
210102	Нэмэгдэл	426,072,900.00	566,087,070.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	19,521,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	37,570,625.67	43,159,209.00
210201	Тэтгэврийн даатгал	6,115,866.00	7,816,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	760,235.00	919,602.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	608,192.00	735,702.00
210204	Ажилгүйдлийн даатгал	135,630.00	159,270.00
210205	Эрүүл мэндийн даатгал	29,950,702.67	33,528,035.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	139,283,767.30	144,020,581.00
210301	Гэрэл, цахилгаан	28,073,800.00	31,059,997.00
210302	Түлш, халаалт	100,638,201.30	101,782,751.00
210303	Цэвэр, бохир ус	10,571,766.00	11,177,833.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	126,815,672.48	57,920,460.00
210401	Бичиг хэрэг	5,094,330.40	3,201,400.00
210402	Тээвэр, шатахуун	40,137,723.50	49,479,797.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,496,358.00	4,442,263.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	832,500.00	797,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	169,065,352.95	49,397,890.22
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	417,086.10	332,623.22
210502	Хоол, хүнс	16,227,636.50	27,112,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	152,420,630.35	21,953,217.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	33,645,068.38	7,769,530.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,500.00	695,500.00
210604	Урсгал засвар	33,636,568.38	7,074,030.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	107,668,400.00	100,657,500.00
210702	Дотоод албан томилолт	107,668,400.00	100,657,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,176,050.00	395,984,179.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,076,800.00	387,639,459.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,684,800.00	1,923,900.00

**Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210803	Даатгалын үйлчилгээ	1,701,150.00	1,680,480.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,169,900.00	1,230,228.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	707,600.00	660,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,719,000.00	1,733,400.00
210807	Газрын төлбөр	1,116,800.00	1,116,712.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>389,143,940.43</b>	<b>271,194,422.17</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,944,650.00	4,871,006.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,670,230.00	2,512,972.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	382,529,060.43	263,810,444.17
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>146,819,448.67</b>	<b>199,629,306.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,200,000.00</b>	<b>8,332,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	8,332,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>144,619,448.67</b>	<b>191,297,306.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	144,619,448.67	191,297,306.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-474,051,969.63</b>	<b>475,742,534.11</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-484,324,935.84</b>	<b>475,742,534.11</b>

## 4.2 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,022,299,229.00</b>	<b>2,780,089,090.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>300,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	300,000.00
120009	Бусад орлого	00.00	300,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,022,299,229.00</b>	<b>2,779,789,090.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,882,643,000.00</b>	<b>2,186,422,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,882,643,000.00	2,186,422,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>139,656,229.00</b>	<b>593,366,290.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,912,997.00	1,712,700.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,987,140.00	216,089,290.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	102,075,000.00	352,688,984.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,681,092.00	22,875,316.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,019,879,229.00</b>	<b>2,710,972,831.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,019,879,229.00</b>	<b>2,710,972,831.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,873,059,780.33</b>	<b>2,511,213,421.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,498,514,640.00</b>	<b>1,697,680,478.00</b>
210101	Үндсэн цалин	1,037,000,840.00	1,112,072,408.00
210102	Нэмэгдэл	426,072,900.00	566,087,070.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	19,521,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>37,604,589.00</b>	<b>43,159,209.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	6,115,866.00	7,816,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	760,235.00	919,602.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	608,192.00	735,702.00
210204	Ажилгүйдлийн даатгал	135,630.00	159,270.00
210205	Эрүүл мэндийн даатгал	29,984,666.00	33,528,035.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>143,285,006.00</b>	<b>143,252,206.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	25,937,828.00	31,059,997.00
210302	Түлш, халаалт	106,775,412.00	101,014,376.00
210303	Цэвэр, бохир ус	10,571,766.00	11,177,833.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>40,216,239.40</b>	<b>53,896,349.00</b>
210401	Бичиг хэрэг	1,998,249.40	3,545,950.00
210402	Тээвэр, шатахуун	33,829,332.00	45,113,336.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,556,158.00	4,440,063.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	832,500.00	797,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>16,825,583.00</b>	<b>50,908,820.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	522,630.00	989,250.00
210502	Хоол, хүнс	15,881,540.00	49,097,443.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	421,413.00	822,127.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,331,599.93</b>	<b>27,104,778.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	261,000.00	23,696,470.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	30,000.00	132,660.00
210604	Урсгал засвар	3,040,599.93	3,275,648.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>107,668,400.00</b>	<b>100,657,500.00</b>
210702	Дотоод албан томиллолт	107,668,400.00	100,657,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>18,633,250.00</b>	<b>387,170,103.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,534,000.00	378,825,383.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,684,800.00	1,923,900.00

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	1,701,150.00	1,680,480.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,170,300.00	1,230,228.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	707,200.00	660,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,719,000.00	1,733,400.00
210807	Газрын төлбөр	1,116,800.00	1,116,712.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,980,473.00</b>	<b>7,383,978.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,916,273.00	4,871,006.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,064,200.00	2,512,972.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>146,819,448.67</b>	<b>199,759,410.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,200,000.00</b>	<b>8,332,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	8,332,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>144,619,448.67</b>	<b>191,427,410.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	144,619,448.67	191,297,306.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	130,104.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>2,420,000.00</u></b>	<b><u>69,116,259.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>2,420,000.00</b>	<b>69,116,259.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,420,000.00</b>	<b>69,116,259.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,420,000.00</b>	<b>69,116,259.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,420,000.00	69,116,259.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-2,420,000.00</u></b>	<b><u>-69,116,259.00</u></b>

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,564,959,256.78</b>	<b>447,696,571.97</b>	<b>1,378,638,544.32</b>	<b>4,391,294,373.07</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	913,489.00	<b>913,489.00</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,564,959,256.78</b>	<b>447,696,571.97</b>	<b>1,379,552,033.32</b>	<b>4,392,207,862.07</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-913,489.00	00.00	<b>-913,489.00</b>
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	<b>00.00</b>
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	<b>00.00</b>
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	<b>00.00</b>
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	475,742,534.11	<b>475,742,534.11</b>
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,564,959,256.78</b>	<b>446,783,082.97</b>	<b>1,855,294,567.43</b>	<b>4,867,036,907.18</b>

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,186,422,800.00	1,995,425,494.00	190,997,306.00	91.26
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,186,422,800.00	1,995,425,494.00	190,997,306.00	91.26
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,178,022,800.00	1,987,093,494.00	190,929,306.00	91.23
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,865,362,700.00	1,680,728,095.00	184,634,605.00	90.10
Үндсэн цалин	1,180,312,900.00	1,095,120,025.00	85,192,875.00	92.78
Нэмэгдэл	664,248,500.00	566,087,070.00	98,161,430.00	85.22
Унаа хоолны хөнгөлөлт	20,801,300.00	19,521,000.00	1,280,300.00	93.85
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	49,193,700.00	43,159,209.00	6,034,491.00	87.73
Тэтгэврийн даатгал	9,203,000.00	7,816,600.00	1,386,400.00	84.94
Тэтгэмжийн даатгал	1,082,000.00	919,602.00	162,398.00	84.99
ҮОМШӨ-ний даатгал	866,700.00	735,702.00	130,998.00	84.89
Ажилгүйдлийн даатгал	217,100.00	159,270.00	57,830.00	73.36
Эрүүл мэндийн даатгал	37,824,900.00	33,528,035.00	4,296,865.00	88.64
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	143,286,600.00	143,252,206.00	34,394.00	99.98
Гэрэл, цахилгаан	23,809,700.00	31,059,997.00	-7,250,297.00	130.45
Түлш, халаалт	104,829,700.00	101,014,376.00	3,815,324.00	96.36
Цэвэр, бохир ус	14,647,200.00	11,177,833.00	3,469,367.00	76.31
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	46,965,000.00	46,963,358.00	1,642.00	100.00
Бичиг хэрэг	2,115,100.00	2,124,850.00	-9,750.00	100.46
Тээвэр, шатахуун	39,308,700.00	39,601,445.00	-292,745.00	100.74
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,451,400.00	4,440,063.00	11,337.00	99.75
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,089,800.00	797,000.00	292,800.00	73.13
<b>Нормативт зардал</b>	50,922,900.00	50,908,820.00	14,080.00	99.97
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	990,000.00	989,250.00	750.00	99.92
Хоол, хүнс	49,481,500.00	49,097,443.00	384,057.00	99.22
Нормын хувцас, зөөлөн эдлэл	451,400.00	822,127.00	-370,727.00	182.13
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,751,600.00	3,751,308.00	292.00	99.99
Багаж, техник, хэрэгсэл	420,700.00	343,000.00	77,700.00	81.53
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	641,500.00	132,660.00	508,840.00	20.68
Урсгал засвар	2,689,400.00	3,275,648.00	-586,248.00	121.80
<b>Томилголт, зочны зардал</b>	2,605,400.00	2,601,800.00	3,600.00	99.86
Дотоод албан томилголт	2,605,400.00	2,601,800.00	3,600.00	99.86
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,504,100.00	8,344,720.00	159,380.00	98.13
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,400.00	1,923,900.00	56,500.00	97.15
Даатгалын үйлчилгээ	1,702,800.00	1,680,480.00	22,320.00	98.69
Тээврийн хэрэгслийн татвар	1,242,500.00	1,230,228.00	12,272.00	99.01
Тээврийн хэрэгслийн оношлогоо	728,200.00	660,000.00	68,200.00	90.63
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,733,400.00	1,733,400.00	00.00	100.00
Газрын төлбөр	1,116,800.00	1,116,712.00	88.00	99.99

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,430,800.00	7,383,978.00	46,822.00	99.37
Бараа үйлчилгээний бусад зардал	4,916,600.00	4,871,006.00	45,594.00	99.07
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,514,200.00	2,512,972.00	1,228.00	99.95
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	8,400,000.00	8,332,000.00	68,000.00	99.19
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	8,400,000.00	8,332,000.00	68,000.00	99.19
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,400,000.00	8,332,000.00	68,000.00	99.19
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,186,422,800.00	2,186,422,800.00	00.00	100.00
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,186,422,800.00	2,186,422,800.00	00.00	100.00
Улсын төсвөөс санхүүжих	2,186,422,800.00	2,186,422,800.00	00.00	100.00

#### 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>593,366,290.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>593,366,290.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	593,236,186.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	16,952,383.00
210101	Үндсэн цалин	-	16,952,383.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	6,932,991.00
210401	Бичиг хэрэг	-	1,421,100.00
210402	Тээвэр, шатахуун	-	5,511,891.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	23,703,470.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	23,703,470.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	98,055,700.00
210702	Дотоод албан томилолт	-	98,055,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	447,591,642.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	447,591,642.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>130,104.00</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	130,104.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	130,104.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>593,366,290.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>593,366,290.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,712,700.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	216,089,290.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	352,688,984.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	22,875,316.00